

№ 13 / 2020 оны 11-р сар

## Адууны хаант улс мөн үү?

*Сэрүүн бүсэд хамаарагдах, харьцангуй онгон байдлаа хадгалж үлдсэн тал хээрийн экосистем нь зөвхөн Төв Азид л байна. Тэдгээр нь ховордсон адууны хоёр төрөл болох тахь болон хулангийн хувьд "хаант улс" буюу хамгийн сүүлийн орогнох газрууд болоод байна.*

Зургийг © С.Нацагдорж



Эртний адуу болон түүний амьдрах орчныг хамгаалцгаая

## Зэрлэг адууг хайрлан хамгаалахад хамтрагч **эрхэм анд нар аа,**



Манай гаригийн биологийн олон янз байдлыг хадгалах тал дээр санаа тавьдаг хэнд ч сонголт хийх арвин боломж байна. Дэлхийн байгаль хамгаалах холбооны (IUCN) Улаан жагсаалтад устаж үгүй болох аюулд орсон 32000 гаруй зүйл өнөөгийн байдлаар бүртгэгджээ. Энэ нь

одоогор бүртгэгдсэн байгаа 120'000 зүйлийн 27 хувь буюу хоёр нутагтан амьтдын 41 хувь, хөхтөн амьтдын 26 хувь, шилмүүст модны 34 хувь, шувууны 14 хувь, акул болон налуу загасны 30 хувь, шүрэн хадны 33 хувь, зарим төрлийн хавч хэлбэртний 28 хувь байна. Ийм тоо хараад хүн яахаа мэдэхгүй, аль ажлаас нь эхлэхээ мэдэхгүй байж болох юм.

Эргэлзээд зүгээр байгаад байвал бас л тус болохгүй юм. Тэгвэл юу тус болох вэ? Эдгээр олон ховордсон төрлүүдийн яг алинд нь бид яаравчлан туслах ёстой вэ? Том навчит улаан модонд уу эсвэл этиопийн чононд уу? Соломоны арлуудын далдуу модны мэлхийд уу эсвэл Меконг мөрний аварга сахалт загасанд уу? Тристаны альбатрос шувуу, мадагаскарын хошуун цээжтэй яст мэлхий, аварга том эрвээхэй эсвэл цоохор ирвэст уу?

Бүх амьтны төрөл зүйлүүд хувьслын үүднээс насны болон ач холбогдолын хувьд ижил бус учраас энэ бол тийм ч энгийнээр шийдэх асуудал биш юм. Экологийн хувьд ч бүгд харьцуулж болохуйц үүрэг гүйцэтгэдэггүй ба гол зүйлүүд нь бүхэл бүтэн идэш тэжээлийн сүлжээг хооронд нь холбож өгдөг. Тийм ч учраас төрөл зүйлийг хамгаалахдаа тодорхой зүйлүүдийн зөвхөн гадна төрх эсвэл экзотик байдалд нь бус, харин тэдний экологийн

ач холбогдол тал дээр тулгуурлах нь зүйтэй юм. Хүн төрөлхтний түүхэнд чухал үүрэг гүйцэтгэж байсан адууг бид дэндүү сайн мэддэг учир тэднийг бид нэн ховордсон устаж буй зүйл гэж бараг боддоггүй. Гэтэл тийм биш юм. Энэхүү зүйлийн эртний төрлүүдээс өнөөдөр зөвхөн 7 зэрлэг төрөл л үлджээ: илжигний 3 төрөл, цоохор тахийн 3 төрөл болон зэрлэг адуу буюу тахь. Саванны цоохор тахь болон түвдийн зэрлэг илжигнээс бусад нь бүгд устах аюулд ороод байгаа юм. Тэднийг хамгаалах арга хэмжээ авахгүй бол энэхүү эртний зэрлэг амьтад устаж үгүй болох магадлалтай болоод байна.

Ийм зүйл өнөөгийн гэрийн адууны өвөг дээдэс болох зэрлэг адуунд тохиолдсон юм. Үүнээс урьдчилан сэргийлэх нь ОУТГ-ийн тахийн төлөө тэмцлийн гол үндэслэл юм. Мөн үүний зэрэгцээ бид дэлхийн хэмжээнд зөвхөн Төв Азийн сэрүүн уур амьсгалтай бүсэд үлдсэн тал хээрийн экосистемийг авч үлдэхийг зорьж байна. Учир нь тэнд ховордсон адууны хоёр төрөл болох тахь болон хулангийн хувьд “хаант үлс” буюу хамгийн сүүлийн орогнох газар нь байгаа юм.

Тэгэхээр та зэрлэг байгалиа хамгаалах үйлсэд хэрхэн оролцох талаар бодож байгаа бол бидэндтэй хамтарснаар та зөв газраа хандсан байна. Эртний монголын нүүдэлчин соёл хадгалагдан тогтнож байгаа өвөрмөц, ховордсон экосистемд хамаарах нэн ховор зүйлийн амьд үлдэх нөхцөлийг хангах нь миний хувьд үнэхээр утга учир бүхий үүрэг мэт санагдаж байна. Таньд мөн ингэж санагдаж байна уу?

**Др. Райнхард Шнидрих, Олон Улсын Тахь Группын Ерөнхийлөгч**

**Зургийг: Сүхбаатарын Далайцэрэн**



„Эртний монголын нүүдэлчин соёл хадгалагдан оршин тогтнож байгаа өвөрмөц, ховордсон экосистемд хамаарах нэн ховор зүйлийн төлөө бид тэмцэж байна.“



## Эртний адууны овог асуудалтай тулгараад байна

Зэрлэг адуу бол 55 сая гаруй жил үргэлжилсэн хувьслын сүүлчийн өв залгамжлагч юм. Харин 5 сая жилийн өмнө энэ амьтдын гэр бүл арав гаруй төрөл зүйлээс бүрдэж байв. Өнөөдөр тэднээс зөвхөн ганц нь л үлджээ. Түүнд нь 7 төрөл л багтаж байна: гурван төрлийн цоохор тахь, гурван төрлийн зэрлэг илжиг буюу хулан, мөн сүүлчийн жинхэнэ /кабаллин гэж бас нэрлэдэг/ зэрлэг адуу болох тахь /Пржевальскийн адуу/. Тэд бүгд тал хээр (адуу), саванн (цоохор тахь), хагас цөлд (илжиг) нүүдлэн амьдардаг өвсөн тэжээлтэн амьтад юм. Тэд таатай амьдрах нөхцлийн эрэлд гарч зарим үед улирлын, бүс нутгийн болон орон нутгийн чанартай хол замыг туулдаг юм. Өнөөгийн байдлаар хангалттай бэлчээр нь маш том асуудал болоод байна.

Хүн амын огцом өсөлт нь (өссөж буй хэрэгцээний хамт) адууны төрлийн амьтдын амьдрах орчныг маш ихээр хувааж өөрчилсөн ба, өнөөдөр зөвхөн Түвдийн зэрлэг илжиг /кианг/ л устгах аюулд ороогүй гэж тооцогддог /IUCN<sup>[1]</sup>-ийн ангиллаар – анхааралд өртөхөөргүй зүйл/. Тал газрын цоохор тахь болон азийн зэрлэг илжиг /хулан/ Устгах болзошгүй, уулын болон Грэви цоохор тахь, тахь зэрэг нь /тус бүр нь 2000 хүрэхгүй толгой/ устгах аюулд орсон бол 20-200 толгой үлдсэн африкийн зэрлэг илжиг бүр мөсөн устгах бодит аюулд орсон амьтдын тоонд оржээ.

Дэлхий даяр зэрлэг адууны төрөл зүйлүүд асар том дарамтанд байдаг. Эдгээр амьтдыг хамгаалах шийдэмгий арга хэмжээ авахгүй бол тэдний ирээдүй маш бүрхэг харагдаж байна. Үүний зэрэгцээ анхны төрөл зүйл нь бүрэн эсвэл бараг бүрэн утсан төрөл зүйлийн олон сая гаршуулсан адуу болон


илжиг байдаг. Гэхдээ зэрлэг өвөг дээдэс нь устаж үгүй болсны экологийн үр дагаварыг энэ нь нөхөж чадахгүй юм. Яагаад гэвэл эдгээр нь амьдрах орчны биологийн олон янз байдлын гол зүйл юм. Хивдэггүй болохоор ходоод гэдсэнд байгаа гуур хорхой идсэн өвс тэжээлийг боловсруулж задалдаг тул бэлчээр мүү гэж голдоггүй. Зэрлэг адуу нь үржил шимгүй тэжээлийг өндөр чанартай бордоо болгон хувиргаж, түүнд агуулагддаг бүхэл үрийг өргөн талбайд тараадаг. Ингэснээр өөрсдийн тархац нутаг бэлчээрийг эко байдлаар хадгалж үлддэг.

Түлхүүр төрөл зүйлүүд, түүний дотор мегафауны төлөөллүүдийг, устгах явдал нь хүн төрөлхтний зүгээс байгальд учруулж буй хамгийн ноцтой хор уршиг бүхий нөлөөлөл байж болох юм<sup>[2]</sup>. Гэвч тэр сөрөг нөлөөллийн үр дагавар нь урт хугацааны дараа илэрдэг тул түүнийг тэр болгон анзаардаггүй. Янз бүрийн экосистем дээр хийсэн туршилтаас харахад, үндсэн төрөл зүйлүүд устаж үгүй болох нь экологийн уялдаа холбоог өөрчилж, том талбайг хамарсан газар нутаг ямар ч амьдралгүй болтлоо доройтох магадлалтай юм.

Иймд ховордсон ан амьтдыг хамгаалах, тахийн жишээн дээр зэрлэг байгальд нь сэргээн нутагшуулах нь илүү үр өгөөжтөй юм. Хүн төрөлхтний түүхэнд чухал байр суурь эзэлсэн энэ амьтны төрөл зүйлийг бид эргэлт буцалтгүй алдаж болохгүй!

[1] IUCN: Дэлхийн байгаль хамгаалах холбоо

[2] Estes JA et al.: Trophic Downgrading of Planet Earth. Science 2011, Vol. 333: 301-306



Түвдийн хулангаас бусад зэрлэг адууны бүх төрөл зүйл өмнөх тархацынхаа ихэнх хэсгийг алджээ. Долоон зүйлийн тав нь устгах аюулд ороод байна. Африкийн зэрлэг илжиг устгах аюулд орж, эртний зэрлэг адуу болох тахь нь зэрлэг байгальд устаж үгүй болсон бөгөөд одоо зөвхөн Монгол болон Хятадад цөөн тооны популяци л эрх чөлөөтэй амьдардаг. Хэдэн мянган жилийн өмнө африкийн болон азийн зэрлэг илжигний тархсан газар нутаг нь Хойд Африкийн хагас цөл газрыг бүхэлд нь эзэлж байсан юм. Харин эртний зэрлэг адууны тархсан газар нь Евроази тивийн хээрийн бүсийг /ягаанаар тэмдэглэсэн хэсэг/ бүхэлд нь хамаарч байв.

Зэрлэг адуу нь үржил шимгүй тэжээлийг өндөр чанартай бордоо болгон хувиргаж, түүнд агуулагддаг бүхэл үрийг өргөн талбайд тараадаг.

## Хамгаалах зүйл: маш онцгой экосистем

ГИДЦГ-ын “Б” хэсэг дахь манай хөтөлбөрийн шүхэр төрөл зүйл нь эртний зэрлэг адуу болох тахь юм. Энэ ховордсон амьтдыг хамгаалснаар бид мөн тэдний амьдрах орчныг хадгалан хамгаалж байгаа. Энэ бол сэрүүн бүсийн харьцангуй байгалийн онгон байдлаа хадгалж үлдсэн тал хээрийн сүүлийн амьдрах орчны нэг юм. Энд хэд хэдэн төрлийн нүүдлийн туйрайтан амьтад амьдардаг бөгөөд тэдний дотор дэлхийд үлдсэн хамгийн том хулангийн сүрэг байдаг. Тэд шилжилт хөдөлгөөн ихтэй байдаг тул энэ нь тэднийг эмзэг байдалд хүргэдэг. Энд мөн дэлхийн хэмжээнд устах аюултай тулгараад байгаа хөхтөн амьтад болох зээр, аргаль болон цоохор ирвэс амьдардаг. Энэ нутагт нийт 410 зүйл ургамал, 49 хөхтөн, 15 төрлийн мөлхөгч болон хоёр нутагтан, 150 гаруй төрлийн шувуу бүртгэгдсэн байна.<sup>[3]</sup> Мөн энэ тусгай хамгаалалттай газар 140 өрх, 75'000 мянган бог малын хамт өвөлждөг байна.

Энэ нь элсэн цөл биш, харин тал хээр газар болон өндөр уулсын дунд орших толгодоос бүрдэг бөгөөд хагас хуурай Зүүнгарын говийн үргэлжлэл, Алтай болон Тяньшааны хооронд орших өргөн уудам тал газар юм. Далайн эргээс хамгийн их алслагдсан энэ бүс нутаг эрс тэс уур амьсгалтай, богино хугацаанд үргэлжлэх зуны улиралд агаарын температур 40°C хүрч, өвөл нь -40° хүртэл буурдаг ба жилд дөнгөж 100 мм хур тунадас ордог байдаг байна.

Томоохон нуур, хөв цөөрмийн орчим амьтан ургамлаар баян байдаг бөгөөд тэдгээрээс хоёр нь хэдэн километр үргэлжилдэг. Тариалангийн жижиг талбайнуудыг усалдаг жижиг гол нь зөвхөн улирлын чанартай урсдаг. Гол ургамлын

зүйлүүд нь саваан булган сүүл, агь, буурцагтан, шоргор лууль болон зөвхөн Төв Азид ургадаг ховордоод байгаа загийн бут юм.

Амьтны аймагт мэрэгч амьтад зонхилдог бөгөөд үүнээс чичүүл, алагдаага, шишүүхэй зэрэг 25 зүйл бүртгэгдсэн байна. Мөн энд бор туулай, монгол огдой, цоохор хонин гүрвэл, саарал чоно, шар үнэг, хярс, шилүүс мий, мануул мий, цоохор ирвэс, янгир ямаа зэрэг амьтад амьдардаг. Харин ажиглахад хамгийн хялбар нь шувууд бөгөөд эдгээрээс зөвхөн дархан цаазат газрын баруун хэсэгт л гэхэд бараг 100 зүйл тогтоогдсон бөгөөд ихэнх нь нягтрал багатай байдаг. Хамгийн их анхааралд өртдөг нь Монгол ногтруу, Цармын бүргэд, Тарважи бүргэд болон Нөмрөг тас гэх мэт тусгай хамгаалалттай газрын 12 төрлийн махчин шувуу юм.

Хойд Америк болон Евразийн их хэмжээний өөрчлөлтөнд өртсөн тал хээрийн ихэнх газруудтай харьцуулахад энэ эмзэг байгалийн тогтолцоо нь харьцангуй хэвийн байдалтай байгаа. Гэсэн хэдий ч уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн хомсдол, ялангуяа ноолуурын чиглэлийн ямааны тоо толгойн өсөлт, дархан цаазат газрын ойр орчны бүсэд хууль ёсны болон хууль бусаар ашиг малтмал олборлох зэрэг эрсдлүүд нэлээд их байна. Бид 2019-2023 оны менежментийн төлөвлөгөөнийхөө хүрээнд эдгээр аюул эрсдлийг арилгах зорилгоор Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллаж байна.

<sup>[3]</sup> Kaczensky P, Walzer C, Steinhauer-Burkart B: Говийн их Дархан цаазат газрын “Б” хэсэг, зэрлэг адууны хоргодох газар. ECO Nature Edition, Байгалийн гарын авлага No 3, Монгол Улс 2004. ISBN 3-935803-20-6



Зураг: © Отгонбаяр Батжаргал (Соотон алагдаага, Алтайн хойлог, Өмхий хүрэн, Өвөгт тогоруу)



© Петра Каченски (ургамалын аймаг), Ш.Эрдэнэпүрэв (ГИДЦГын Б хэсэг, Алагхайрхан уул)



ГИДЦГ-ын “Б” хэсгийн шим мандлын нөөц газар нь сэрүүн бүсийн харьцангуй бүрэн бүтэн байдлаа хадгалж үлдсэн тал хээрийн хамгийн сүүлчийн амьдрах орчны нэг юм.



## Эртний соёлын өвийг хадгалах

Зүүнгарын говь нь хүн амьдардаггүй зэрлэг газар биш юм; эрт дээр үеэс энд малчид малаа бэлчээж амьдарч байсан. Шим мандлын нөөц газар нь эртний уламжлалт амьдралын хэв маягаа хадгалан үлдэх ёстой юм. Ердийн малчин айл хэдэн зуун хонь, ямаатай бөгөөд түүнийхээ мах, сүү, ноос, арьс шир гэсэн малын гаралтай бүтээгдхүүнээ ашиглан амьдардаг. Бог малаас гадна, малчид адуу, тэмээ, үхэр, заримдаа сарлагтай байдаг. Тэдний уламжлалт амьдралын хэв маяг нь тогтвортой гэж хэлж болно: яагаад гэвэл малаас авсан шимийг бүрэн ашиглаж, илүүдэл хог хаягдал гаргахгүй бүрэн ашиглаж амьдардаг буюу нэгэн хаалттай бүтэн тойрог гэсэн үг. Гэвч гэр бүлд, жишээлбэл тээврийн хэрэгсэл, нарны зай хураагуур, хөргөгч, түлш худалдан авах эсвэл хүүхдийн боловсролд мөнгө зарах үед бэлэн мөнгөний хэрэгцээ шаардлагатай болсны дараа энэ нь өөрчлөгдөнө. Энэ зорилгоор малчид бараа, ялангуяа ноолуур, ноос, цагаан идээ, махан бүтээгдхүүн зарж борлуулж эхэлдэг, бөгөөд ноолуур нь хамгийн их ашиг авчирдаг. Ингэснээр нэг айл өөрийн орлогыг гурав дахин нэмэгдүүлэх боломжтой. Энэ нь тогтвортой байхаас илүү ихийг үйлдвэрлэх хүчтэй хөшүүргийг бий болгоод байна. Өнөөдөр Монгол улс нь дэлхийн зах зээл дээр ноолуурын том үйлдвэрлэгчдийн нэг буюу БНХАУ-ын дараа ордог. Мөн дэлхийн зах зээлийн ¼ үйлдвэрлэдэг ба монголын ноолуурын төв бол говийн аймгууд юм. Нэг ямаанаас жилдээ 300 гр ноолуурыг хавар самнаж авах боломжтой. 2018 онд 14 орчим ам.долларын ашигтай байсан байна.

Хэрэв мал сүргийн тоо, хэмжээ хэт их нэмэгдвэл нүүдэлчдийн ашигладаг бэлчээр эрсдэлд ордог. Монгол улсын хот суурин газрын эргэн тойрон дахь цөлжилт ихсэж маш их гэсэн шатлалд орсон; энэ нь хүн амын хурдацтай өсөлттэй холбоотой. Монгол орны өргөн уудам газар нутгийг хэт их ашигласны үр дүн юм. Ноолуурын эрэлт өндөр байгаа нь асуудлыг улам хүндрүүлж байна. Үүний зэрэгцээ малчдын бог малын биомасс нь зэрлэг туруутан амьтдынхаас бараг хорь дахин их байна.<sup>[4]</sup> Ийм их тооны мал нь олон зүйлийн зэрлэг амьтдын тэжээлийн нөөц болох бэлчээрийг доройтуулж улмаар амьд үлдэх боломжийг бууруулдаг.

Гэсэн хэдий ч үнэт экосистемийг орон нутгийн хүн амын хүсэл зорилгоос ангид бус харин хамтдаа хадгалан хамгаалах ёстой билээ. Үнэхээр экосистем, нүүдэлчдийн соёл хамтран тогтвортой байдлын үндсэн дээр л аль алин оршин тогтнож чадна. Тиймээс ОУТГ нь бэлчээрийн оновчтой менежментийг тодорхойлоход чиглэсэн судалгааг санхүүжүүлж байна. Судалгаанд ургамалжилт, малын биомассын хэрэглээ, малын гаралтай бүтээгдхүүний үйлдвэрлэл, мал сүргийн шилжилт хөдөлгөөний хэв маяг, малчин өрхийн ашиг сонирхлын талаарх судалгааг багтаасан болно. Орон нутгийн хүмүүс дархан цаазат газрын үйл ажиллагаанд илүү их хамрагдаж, мэдээлэл авахыг хүсч, аялал жуулчлалаас нэмэлт орлого олох найдлага тавьж байна.

<sup>[4]</sup> Berger J, Bayarbaatar B, Charudutt M: Ноолуурын зах зээлийн даяаршил ба Төв Ази дахь том хөхтөн амьтдын бууралт. Байгаль хамгаалах биологи 2013 он



Зургийг: © Uli Rutz

Экосистем ба нүүдэлчдийн соёл хоёулаа аль алин зөвхөн тогтвортой байдлын үндсэн дээр л оршин тогтнох боломжтой.

## 2020 онд бидний хийсэн ажлууд


SARS-CoV-2-ыг үл харгалзан ОУТГ нь одоогийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, ялангуяа дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ:

- Шинэ гэрээт 14 байгаль хамгаалагчдын сургалт
- ДЦГ-ын шинэ хилийн дагуу мэдээллийн самбар болон хилийн шонгуудыг байрлуулав
- Ховд их сургуультай хамтран ДЦГ-ын усны менежментийг оновчтой болгох зорилгоор үст цэгүүдийн судалгааг эхлүүлсэн
- Тухайн орон нутагт аялал жуулчлал хөгжүүлэх боломж болон орон нутгийн хүн амын нэмэлт орлогын эх үүсвэрийн талаарх судалгаа
- Алтай сум (Ховд аймаг) дахь ДЦГ-ын хамгаалалтын захиргааны шинэ төвийн төслийн ажил
- ОУТГ болон Монголын Байгаль орчин, аялал жуулчлалын яам хооронд байгуулсан гэрээг шинэчлэх
- Монгол улсад тахийг сэргээн нутагшуулж буй 3 хамгаалалттай газруудад байгаа тахийн популяцийн нэгдсэн менежмент (ГИДЦГ “Б” хэсэг, Хомийн тал БЦГ, Хустайн БЦГ)

## Таны 2020 оны хандивыг бид юунд зарцуулав

Хандивын 86% нь ГИДЦГ “Б” хэсгийн экосистем болон тэнд амьдардаг зэрлэг адууны өвөг болох тахийг хамгаалахад шууд зарцуулсан байна. Хандивын 14% -ийг Швейцар улс дахь ОУТГ-ын багийн үйл ажиллагааны зардал (удирдах зөвлөлийн гишүүд сайн дурын үндсэн дээр үнэ хөлсгүй ажилладаг), мэдээ мэдээлэл боловсруулах, түүнчлэн шинэ вэбсайт болон Тахийн мэдээ сонин гаргах зэрэгт зарцуулжээ.

### ОУТГ-ын зардлын задаргаа, 2020 он



### Шинэ цахим хуудас

Манай шинэ [www.savethewildhorse.org](http://www.savethewildhorse.org) цахим хуудаст тавтай зочилно уу

Бид байгаль хамгаалах хөтөлбөрийнхөө талаар илүү сайн ойлголт өгөхийн тулд цахим хуудасны агуулгыг илүү сайжруулж, илүү олон зураг оруулав. Тахь, Зүүнгарын говийн экосистем, нүүдэлчдийн соёл, ОУТГ-ын зорилго, үйл ажиллагааны талаар та маш их зүйлийг олж мэдэх болно. Нэмэлт мэдээлэл авахын хүсвэл манай мэдээ мэдээллийн төвд зочилж тайлан, протокол, эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл, “Тахийн мэдээ” сонингийн цахим хувилбарыг үнших боломжтой. Тавтай морилно уу !

Жич: Одоо PayPal болон кредит картаар дамжуулан онлайн хэлбэрээр хандив авах боломжтой боллоо.





## Зүйлийн хөрөг: **Цоохор ирвэс**<sup>[5]</sup>

ГИДЦГ “Б” хэсгийг хүрээлж буй уулс: хойд талаараа Алтайн нуруу, 2000 км урттай; өмнөд хэсэгт Тахийн шар нуруу; зүүн хэсэгт Алагхайрхан уулс сүндэрлэнэ оршдог. Тус ДЦГ-ын нутаг дэвсгэрийн хэмжээ 2019 онд хоёр дахин нэмэгдсэн тул хамгаалалтад байгаа уулархаг экосистем түүнийг даган нэмэгдсэн байна. Энэ нь тухайн өндөр ууланд амьдрахад дасан зохицсон төрөл зүйлийн хувьд өсөн үржих таатай нөхцөл бүрдсэн юм. Үүний гол төлөөлөгчдөд янгир, аргаль мөн ирвэс (*Panthera uncia*) багтаж байна. Боровтор эсвэл шаравтар туяатай саарал зүстэй, хүчирхэг том тавхайтай, урт өтгөн үстэй сүүлтэй, муурын овгийн хамгийн том биетэй төлөөлөгч зүйл болох ирвэс нь Төв Азийн нурууны бэлгэдэл юм. Нэмээд дурдахад, бүрэнхий, шөнийн идэвхитэй энэ махчин амьтан өөрийн экосистемд гол үүрэг гүйцэтгэдэг.

Хуурай уур амьсгал, сийрэг ургамалт идэш тэжээлтэй хуурай цөл, цөлөрхөг орчинд ан гөрөө хийхэд том муурын хувьд таатай орчин биш юм. Гэхдээ цоохор ирвэс нь зөвхөн уулын ой, бэлчээрт төдийгүй үржил шимгүй, эгц нурууны энгэр, цөл шиг өндөрлөг газарт амьдардаг. Монголд цоохор ирвэс нь задгай тэгш талд хоорондоо 20-65 км хүргэлх зайтай тусдаа газруудад өөрийн бүсийг тогтоосон байдаг. Тэд өөрөөс нь гурав дахин их биеийн жинтэй олзыг агнах чадвартай байдаг. Тэдний гол олзыг аргаль, янгир бүрдүүлдэг боловч тархацынхаа зарим хэсэгт зэрлэг илжиг, зэрлэг гахай эсвэл Мунтьяк гөрөөсөөр хооллож болно. Ялангуяа зуны улиралд тарвага, шоргоолж, туулай, оготно, гургуул зэргийг агнадаг байна.

Бие гүйцсэн ирвэсэнд өдөрт 1.5 кг орчим мах шаардагддаг. Тиймээс цоохор ирвэсийн хувьд аргалийн мах нь нэлээн хэдэн хоногийн хүнсний хэрэгцээг хангах болно; гүемтэй эм ирвэс гурав дахин их хэрэгцээтэй байдаг. Зуны улиралд цоохор ирвэс 2500-6000 м өндөр уулсын гүн хавцал жалга, хад цохиот эгц хажуу зэрэг гөрөөл амьтанг отох, гэтэх байдлаар ойртож, довтлох

### Цоохор ирвэсийн таних шинж:

- Урт сунасан биетэй, харьцангуй богино хөлтэй, урт сүүлтэй, 22-52 кг жинтэй.
- Өдөр, шөнийн цагаар идэвхтэй байдаг боловч гол төлөв бүрэнхий, шөнийн цагаар гол төлөв идэвхтэй; 20.00 цагаас 04:00 цагийн хооронд. Ихэвчлэн үдээс хойш амардаг.
- Ганцаараа амьдардаг (гүемтэй эм цоохор ирвэснээс бусад). Амьдрах орчны хувьд 20 км<sup>2</sup> орчим, Монгол шиг өргөн уудам нутагт олзны нягтрал багатай газар 60-600 км<sup>2</sup>. Өөрийн эзэмшил нутгаа зураас, шээс болон ялгадасаараа тэмдэглэдэг.
- Ороо нийллэг 1-3 дугаар сард болно. Хээл тээх хугацаа дунджаар 98-104 хоног. Эм ирвэс 2-3 гүем төрүүлнэ.
- Төрөх жин 300-600 гр, долоо хоног бүр 300-500 гр-аар нэмэгдэж; 2 сартайдаа ойролцоогоор 4 кг жинтэй, хөхнөөс гарахад (10 долоо хоног) 6 кг орчим жинтэй байдаг. Гүемнүүд 2-4 сартайгаасаа эхлэн 1.5 орчим нас хүртлээ ээжийгээ дагаж явдаг. Хоёр, гурван настайдаа бэлэг боловсорно, 4 орчим насандаа үржилд ордог.



*Цоохор ирвэс нь өндөрөг газрын махчин амьтан тул Төв Азийн нуруудын экосистемд гол үүрэг гүйцэтгэдэг.*

*Зургийг: © „Tambako the Jaguar“ 2013*

боломжтой бартаат газарт илүү ан хийдэг бол өвлийн улиралд нам дор газар руу явдаг. Маш хурдтай хараа сайтай тул гэнэт олзруу дайрч, дараа нь заримдаа хэдэн зуун метрээс доош налуугаар хөөнө.

Ойролцоогоор 3000 орчим цоохор ирвэс дэлхийд Алтайн нуруунаас Тянь-Шань, Тэнгэруулаар дамжин Гималайн нуруу, Түвдийн өндөрлөг газар хүртэлх өргөн нутагт тархан амьдарч байна. Энэ зүйлийн хамгаалалын статус нь эмзэг ангилалд багтдаг бөгөөд тоо толгой нь цөөрч байна. Энэ нь хэд хэдэн шалтгаантай байна. Тэдний ан болох амьтдын амьдрах орчин гэрийн малын бэлчээртэй давхцсанаас болж цөөрч байна. Иймд цоохор ирвэс гэрийн мал агнаснаас болж амь үрэгддэг. Түүгээр ч үл барам хулгайн анчид цоохор ирвэсийн арьс, шир, бусад биеийн хэсгийг Хятад, Монгол, Пакистан, Энэтхэг, Таджикистан улсуудын хууль бус наймаачдад худалдаалдаг байна. Уур амьсгалын өөрчлөлт, хүн амын тоо олшрох, уул уурхай, засмал зам, төмөр зам зэрэг үйл ажиллагааны аль алинаас нь шинэ эрсдлүүд гарч ирээд байна.

Цоохор ирвэсийг хамгаалахын тулд нутгийн тариаланчид, малчид энэ эмзэг ангиллалын тулхүүр төрөл зүйлийн амьтны экологийн ач холбогдлыг илүү сайн ойлгох хэрэгтэй байна. Мөн ГИДЦГ “Б” хэсэгт байгаа шиг цоохор ирвэсийн нэмэлт амьдрах орон зүйг нь тэлэх шаардлагатай байна.

<sup>[5]</sup> Sunquist ME & Sunquist FC, in: Wilson DE & Mittermeier RA eds. (2009): Дэлхийн хөхтөн амьтдын гарын авлага, Боть. 1, Lynx Edicions, Барселона

Цоохор ирвэсүүд олон төрлийн аюул заналхийлэлд өртөөд байна. Тэднийг хамгаалахын тулд нэмэлт аюулгүй амьдрах орчныг бий болгох нь чухал юм.

## Зэрлэг адуу Тахийн ирээдүйг хамтдаа хамгаалцгаая



“Говийн их шим мандлын нөөц газар нь өвөрмөц ургамал, амьтны аймгаас гадна нүүдэлчин морьтон ард түмний олон мянган жилийн турш уламжлалт аж ахуйгаараа амьдарч ирсэн нутаг юм. Бид энэ өвийг хойч үедээ хадгалж үлдээх ёстой!”

Оюунсайханы Ганбаатар, биологич, тахь судлаач, ГИДЦГ “Б” хэсгийн Хамгаалалтын захиргааны дарга

**ОУТГ-ийн гишүүд нь сайн дураар ажилладаг. Бүх хандив тусламж тахийг хамгаалах үйлсэд зарцуулагдах болно.**

Таны хандив бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Хандивын бүх мөнгө зэрлэг адуу тахь болон Төв Азийн тал хээрийн өвөрмөц ургамал, амьтныг хамгаалахад туслах болно. Танд баярлалаа!

150,000 төгрөг

Та ДЦГ-ын өргөтгөлийн хил хязгаарыг тэмдэглэхэд туслах болно.

225,000 төгрөг

Та бэлчээрийн менежментийг оновчтой болгохын тулд цаг уурын станц худалдан авахад хувь нэмэр оруулах болно.

300,000 төгрөг

Та шинээр ажилд орсон байгаль хамгаалагчдын ажлын хэрэгсэл тоног төхөөрөмжийг санхүүжүүлэхэд туслах болно.

600,000 төгрөг

Та шинэ байгаль хамгаалагчдыг сургалтанд хамруулахад туслах болно.

Та нэг байгаль хамгаалагчийн нэг өдрийн цалин болон түүний ажилдаа хэрэглэх материалыг санхүүжүүлнэ.

Зургийг: © Cyril Ruoso

### Та “Тахийн найз нөхөд” болох уу?

- Хувь хүний гишүүнчлэлийн жилийн хураамж **130,000 төгрөг**
- Оюутан, залууст зориулсан “Унага” гишүүний хураамж **50,000 төгрөг**

### Хандивын данс

Олон Улсын Тахь Группын Монгол дахь товчоо

ХХБ

499114883 ам. долл.

499248691 төгрөг



### Эрхлэн гаргасан

ITG International Takhi Group  
Friends of the Wild Horse  
c/o Stiftung Wildnispark Zurich  
Alte Sihltalstrasse 38  
CH-8135 Sihlwald / ZH  
[www.savethewildhorse.org](http://www.savethewildhorse.org)  
[info@savethewildhorse.org](mailto:info@savethewildhorse.org)  
[itg.ulaanbaatar@gmail.com](mailto:itg.ulaanbaatar@gmail.com)

Байгаль орчинд ээлтэй цаасан дээр хэвлэв. FSC (Ойн Удирдах Зөвлөл) / EX Эко шошгоны цаас

